



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

**Өлсгөлөнгийн үед тусламж  
үзүүлэх тухай**

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 233 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор  
ТУШААХ НЬ:

1. Хан-Уул дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэрт иргэд өлсгөлөн зарласантай холбоотой ЭМС-ын 233 дугаар тушаалын 3.1 заалтын дагуу Эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар ахлуулсан нарийн мэргэжлийн багийг дотор, мэдрэл, мэс засал, дотоод шүүрэл, сэтгэц, зүрх судасны эмч, сувилагч, лаборант нарын бүрэлдэхүүнтэйгээр томилж, мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Эмч нарын баг нь нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийх ба цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ /уураг эрдсүүд, элэгний үйл ажиллагаа, сахар/, ЭХО, зүрхний бичлэг, рентген/флюорографи/ шинжилгээнүүдийг авч өлсгөлөнд оролцогчдын эрүүл мэндийн дүгнэлтийг гаргаж НЭМГ, Хан-Уул дүүргийн тамгын газар, Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэст хүргүүлэхийг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Д.Гэжиймаа-д үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн төвөөс итгэмжлэгдсэн эмчээр дотрын эмч /Д.Соёл-Эрдэнэ/-г томилж, итгэмжлэгдсэн эмч нь өлсгөлөнд оролцогчдод үзлэг, хяналтыг хуваарийн дагуу тогтмол хийж, эрүүл мэндийн төвийн удирдлагад мэдээлэхийг үүрэг болгосугай.

4. Итгэмжлэгдсэн эмч нь өлсгөлөнд оролцогчдод өлсгөлөнгийн хор уршиг, үр дагаварын талаар таниулж, эрүүл ахуй халдвар хамгаалалын дэглэмийн талаар зөвлөгөө өгч ажиллана.


5. Итгэмжлэгдсэн дотрын эмч /Д.Соёл-Эрдэнэ/-г мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг поликлиникийн эрхлэгч /Д.Молор-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

6. Өлсгөлөн зарлагчдад хяналт хийж байгаа итгэмжлэгдсэн эмч нь Олон улсын хэмжээнд мөрддөг эрт сэрэмжлүүлэх үнэлэмжийн дагуу үнэлгээг хийж, 4 буюу түүнээс дээш оноонд хүрсэн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өлсгөлөнг зогсоож, албадан эрчимт эмчилгээнд оруулна.

3 170 7032058

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /Ц.Энхбаясгалан/-д даалгасгай.

ДАРГА Э.БОДЬЦЭЦЭГ

A red rectangular stamp is located in the center of the page. It contains Mongolian text, including the name 'Э.Бодьцэцэг' (E. Bodjtsytsag) and the title 'Дарга' (Director). A black ink signature is written over the stamp.

Хан-Уул эрүүд мэндийн төвийн даргын  
2022 оны 11 дугаар сарын 09-ны өдрийн  
А/УБ -р тушаалын нэгдүгээр хавсралт

Багийн ахлагч-Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга: Д.Гэжиймаа

Нарийн бичгийн дарга: Поликлиникийн эрхлэгч Д. Молор-эрдэнэ

Гишүүд: Мэдрэлийн эмч З.Уранчимэг

Зүрх судасны эмч Ц.Тунгалаг

Мэс заслын эмч С.Дүйнхэржав

Сэтгэцийн эмч Хандармаа

Дотрын эмч О.Баярнэмэх

Дотоод шүүрлийн эмч Д.Болормаа

Дүрс оношлогооны/ЭХО, рентген/ эмч Ж.Норжинсүрэн

Зүрх судасны сувилагч С.Батцэцэг

Рентген техникч- ЭЭ эмч Г.Лхагвасүрэн

Тарианы сувилагч О.Одгэрэл

Лаборант Х.Саранчимэг

Итгэмжлэгдсэн эмч: Дотрын эмч Д.Соёл-Эрдэнэ

Сувилагч Х.Оюунбат

### ОРЛОН АЖИЛЛАХ ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮД:

Томилогдсон:

Орлон ажиллах:

- |   |                   |               |   |            |             |
|---|-------------------|---------------|---|------------|-------------|
| 1 | Итгэмжлэгдсэн эмч | Д.Соёл-Эрдэнэ | 1 | Дотрын эмч | Л.Мэдэхгүй  |
| 2 | Сувилагч          | Х.Оюунбат     | 2 | Сувилагч   | Г.Энхжаргал |
| 3 | Жолооч            | Ц.Мөнхмандах  | 3 | Жолооч     | Б.Одсайхан  |